



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

Дугаар: 2010/11
Огноо: 2010 оны 11-р сарын 18
Эмбарго: 2010 оны 11-р сарын 19-ний Баасан гаригийн 11:00 цаг хүртэл

Монголбанкны Захирлуудын зөвлөлийн 2010 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хурлаар бодлогын хүүг хэвээр хадгалах шийдвэр гаргалаа.

Үндэсний Статистикийн хорооны мэдээгээр 2010 оны 10 дугаар сарын байдлаар инфляци жилийн 11.3 хувь байна. 2010 оны эхний хагаст эрчимтэй нэмэгдэж байсан инфляцийн өсөлт 3-р улирлаас эхлэн буурч, сүүлийн 2 сард харьцангуй тогтворжиж байна.

Монгол Улсын 2011 оны төсвийн төсөлд орж буй өөрчлөлтөөр анхны өргөн барьсан төсвөөс төсвийн нийт зарлага 703 тэрбум төгрөгөөр, нийт алдагдал 476 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэхээр байна. Үүний улмаас инфляци нэмэгдэж мөнгөний бодлогоор эдийн засгийн өсөлтийг дэмжих боломж хязгаарлагдаж байна.

МОНГОЛБАНК